



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, II хороо, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: 70112333, Факс: (976-11) 31-23-15  
E-mail: [info@mrt.gov.mn](mailto:info@mrt.gov.mn), <http://www.mrt.gov.mn>

ТЗДТБХЗГ-ЫН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОБЪЕКТ ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГТ

2016-02-02 № 038-07-068/05

Салбар төмөр замын объектын гэрчилгээг  
түдгэлзүүлэх тухай

“Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5<sup>2</sup>, 10 дугаар зүйл, “Төмөр замын тээврийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.6 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.5.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15,1 дэх хэсгийг тус тус үндэслэн “УБТЗ” ХНН-ийн Толгойт өртөөнд “МҮХК” ХХК-ийн салбар төмөр замын дэвсгэр зургийг газар дээрхи байршилтай тулган шалгаж, бусдын эзэмшил газраар замын зарим хэсэг дайрсан гэх байдлыг шалгаж дараах дүгнэлтийг гаргав.

**ТОДОРХОЙЛОХ НЬ:**

Толгойт өртөөн дэх “МҮХК” ХХК-ийн салбар төмөр зам нь “УБТЗ” ХНН-ийн замаас салаалж үргэлжлэх хэсэгт дараах хоёр дугаар бүхий кадастрын нэгж талбарыг дайрч байна.

Үүнд:

5. “МҮХК” ХХК-ийн бариулсан салбар төмөр замын чиг нь Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр дэх “Грийн радианс” ХХК-ийн 18633309206841 нэгж талбарын дугаартай эзэмшлийн газарт захын шугамаас 10.3м-т 30.9м урттай орсон байна.
6. Иргэн С.Батсуурийн эзэмшлийн 18633309340862 нэгж талбарын дугаартай эзэмшил газарт захын шугамаас 6м зайтай 123.3м урттай тус тус орсон байна.

**ДҮГНЭХ НЬ:**

Дээрх газар ашиглалтын маргааны талаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх хэрэг үүсгэн шалгаж байгаа бөгөөд одоогоор шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй байна.

Иймд 1949 онд Монгол-Оросын Засгийн газар хооронд байгуулсан олон улсын хэлэлцээрийн дагуу “УБТЗ” ХНН-т олгосон төмөр замын зурвас газарт хамаарах уг газрын ашиглалт, эзэмшилтэй холбоотой Сонгинохайрхан дүүргийн өмч, газрын харилцааны алба, “МҮХК” ХХК, “Грийн радианс” ХХК, Иргэн С.Батсуурь нарын хооронд үүссэн маргааныг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс эцэслэн шийдвэрлэх хүртэл 2014 онд тус яамнаас хууль, журмын дагуу “МҮХК” ХХК-д олгосон /Код-О-1-2, №14/46/ дугаартай “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ”-г түдгэлзүүлэх саналтай байна.

Дүгнэлт бичсэн:

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗАМЫН ХЯНАЛТЫН  
МЭРГЭЖИЛТЭН, УЛСЫН БАЙЦААГЧ



С.МАЙДАР